**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 15 өдөр Дугаар 202 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6,7.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.”Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хавсралтад заасан 48,000,000.00 (дөчин найман сая) төгрөгийн балансын үнэ, 45,816,000.00 (дөчин таван сая найман зуун арван зургаан мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг Орхон аймгийн Онцгой байдлын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.”Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 235,791,775.00 (хоёр зуун гучин таван сая долоон зуун ерэн нэгэн мянга долоон зуун далан таван) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 2 ширхэг тээврийн хэрэгслийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож Завхан аймгийн Онцгой байдлын газар, Орхон аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд тус тус балансаас балансад шилжүүлсүгэй.

3.Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Орхон аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар, Завхан аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Ө.Болд, Орхон аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Төгсбаяр, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;
3.2.Хөрөнгийн шинэчлэн тогтоосон үнэ, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
3.3. Автомашины улсын дугаарыг улсын бүртгэл, татвар төлөгчөөс бүртгэлээс хасаж шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

133001446

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 137 дугаар тогтоолын хавсралтын 10 дахь мөрийг хүчингүйд тооцсугай.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны ..06.. дугаар сарын ..15.. өдрийн
..202.. дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

## "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

| д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар | Ашиглалтад орсон он | Балансын үнэ, (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг төгрөг | Шилжүүлэн авах хуулийн этгээд |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | IVECO 4x4 Daily, 66-79 орх, арал-LNYK1SJ054V10023 | 2015 | 48,000,000 | 45,816,000 | 2,184,000 | Орхон аймгийн Онцгой байдлын газар |
| | Нийт дүн | | **48,000,000.00** | **45,816,000.00** | **2,184,000.00** | |
| | | | **(дөчин найман сая)** | **(дөчин таван сая найман зуун арван зургаан мянга)** | **(хоёр сая нэг зуун наян дөрвөн мянга)** | |

ө

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны ..06.. дугаар сарын ..15.. өдрийн
..202.. дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

| д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар | Ашиглалтад орсон огноо | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Шилжүүлэн авах хуулийн этгээд | Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг) | Ашиглах хугацаа (жил) |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Түлш тээвэрлэн цэнэглэгч ачааны машин МАЗ, 20-37орх | 2007 | 147,113,080.00 | Завхан аймгийн Онцгой байдлын газар | 2,000,000.00 | 2 |
| 2 | Тоёота ландкрузейр-100, суудлын, 5665 ОРО, арал-JTEHJOGJ225053053 | 2011 | 88,678,695.00 | Орхон аймгийн Мэргэил сургалт үйлдвэрэлэлийн төв | 2,000,000.00 | 1 |
| | **Нийт дүн** | | **235,791,775.00** | | **4,000,000.00** | |
| | | | **(хоёр зуун гучин таван сая долоон зуун ерэн нэгэн мянга долоон зуун далан таван мянга)** | | **(дөрвөн сая)** | |